Дундговь аймаг

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2023.12.15 Мандалговь хот

| № | Зорилт, арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Түвшин | | | |
| **3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр** | | | | | | | | | |
| 3.3 | Зорилго: 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2024 онд 56-аас доошгүй хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Хангалтын хувь | 2022 | 42.71 | 45.34 | Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 258,8 тонныг үйлдвэрлэж – 10,2 хувийг, “мал төхөөрөх цэг болон бууз баншны үйлдвэр цехэд нийт -502,3 тонн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж -30 хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,3 мян.л-ийг үйлдвэрлэж -1,4 хувийг, өндөг -78,4 тонныг үйлдвэрлэж 28 хувийг тус тус үйлдвэрлэж, хангасан байна.<br>Орон нутгийн үйлдвэрлэлээр нийт 69,6 хувийг хангасан байна. | 100 |
| 3.3.1. | Зорилт: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 221,279.85 сая төгрөг байсныг 2024 онд 294,221.45 сая.төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | - | Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт (сая.төг) | 2022 | 257750.6 | 275986.1 | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 294967.74 сая.төгрөг байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1.1 | Арга хэмжээ: Дундговийн мах арга хэмжээг хэрэгжүүлж сумдад мал, төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр байгуулах | 2021-2024 | ЖДҮХ сан-332,6 сая.төг | Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ (тонн) | 2022 | 2 | 2.5 | Сайнцагаан Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулж буй “Мал төхөөрөх” 4 цэгт үхэр-13, адуу -40, тэмээ-14, хонь-21800, ямаа-7200 толгойг төхөөрч маханд шилжүүлснээр 487 тн мах бэлтгэж, аймгийн болон Улаанбаатар хотын хэрэгцээнд нийлүүлсэн байна. | 68,3 |
| | | | | Шинээр байгуулагдсан мал төхөөрөх жижиг үйлдвэрийн тоо | 2022 | 9 | 12 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайнцагаан сумын “Дэлгэр номт ундраа” ХХК 90,0 сая, Сайхан-Овоо сумын “Эрхэст Ундрага” ХХК 242,64 сая төгрөгийн санхүүжилт авч “Мал, төхөөрч мах, махан бүтээгдэхүүн ангилж савлах“ үйлдвэр, цех байгуулагдсан байна. | |
| 3.3.1.2 | Арга хэмжээ: Хүн амын өвөл, хавар, зуны хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлж махны хангамж, үнийн тогтвортой байдлыг хангах | 2021-2024 | Хувийн хэвшил-604 сая.төг | Тухайн жилд нөөцөлсөн махны хэмжээ (тонн) | 2022 | 100 | 100 | Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч 1 иргэн, 4 ААНэгж стандартын шаардлага хангасан хөргүүртэй болон гүн хөлдөөх агуулахад 735,5 тн мах нөөцөлсөн бөгөөд үхэр-26,5тн, хонь-339тн, ямаа-360тн, тэмээ-10 тн байна. | 100 |
| 3.3.1.3 | Арга хэмжээ: “Дундговь үйлдвэрлэл” арга хэмжээг хэрэгжүүлж орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх хоршоодыг сум бүрд байгуулах | 2021-2024 | - | Байгуулагдсан хоршоодын тоо | 2022 | 9 | 12 | ХХААХҮЯамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран Бизнес эрхлэгч нарт хоршоо хөгжүүлэх сан болон хоршооны тухай ерөнхий ойлголт, хоршоо байгуулагдсанаар давуу талын талаарх сургалтыг 4 удаа 173 иргэнд зохион байгуулсан. | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 98 хоршоо байна. Хоршоодын 40 хувь нь мал аж ахуй түүхий эд бэлтгэл, 4 хувь нь Мал, эмнэлгийн үйлчилгээ, 2 хувь нь модон эдлэл үйлдвэрлэл, 24 хувь нь ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 8 хувь нь Хадгаламж, зээл, 17 хувь нь худалдаа, үйлчилгээ, 5 хувь нь газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.<br>Эрдэнэдалай сумын Далайн баялаг төгөл хоршоо нь Далайн шим болон Арвижих гэсэн 2 малчны бүлэгтэй. Бүлгүүд нь Хүнсний ногоо, сүү цагаан идээ, ногоон тэжээл тариалсан. Үүнээс Хүнсний ногоо болон Сүү, цагаан идээгээ борлуулан хоршооны дундын сандаа 3,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Сайнцагаан сумын иргэн Т.Болортуяа Мянгат Алтан Судар хоршоог үүсгэн байгуулсан. Тус хоршоо нь малын гаралтай түүхий эд худалдан авах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1.4 | <u>Арга хэмжээ:</u> Эдийн засгийн үр ашиг бүхий ажлын байр шинээр бий болгох инновацад суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих | 2021-2024 | ЖДҮХСан-422,6 ХХСан-30,4 ХЭДС-10,0 | Шинээр байгуулагдсан тоо | 2022 | 5 | 5 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайнцагаан сумын “Цутгуурч” ХХК 90,0 сая төгрөгийн санхүүжилт авч “Борц” үйлдвэрлэх цех байгуулаад байна. Сайхан-Овоо сумын Эрхэст Ундарга ХХК 242,6 сая.төгрөг, Сайнцагаан сумын Дэлгэр номт ундраа ХХК 90,0 сая.төгрөгийн санхүүжилт аван мах ангилан савлах цехийг байгуулаад байна.<br>Start-Up хөтөлбөрөөс Сайнцагаан сумын Б.Ариунзаяа ахлагчтай “Мандалын шим” баг Хөрсгүй тэжээлийн ургамал тариалах чиглэлээр 10,0 сая.төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.<br>Дэлгэрхангай сумын малчин Б.Хосбат нь ХХСангаас 30,4 сая.төгрөгийн зээл авч газын баллоны саваар үйлдвэрлэсэн зуухаа патентжуулан зах зээлд борлуулж байна. Энэ онд 53 ширхэг зуух үйлдвэрлэн 21.2 сая.төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | 50 |
| | | | | Хөрөнгийн хэмжээ сая.төг | 2022 | 160 | 160 | ЖДҮХСан-422,6 сая.төг<br>ХХСан-30,4 сая.төгрөг<br>ХЭДС-10,0 сая.төгрөг | |
| | | | | Ажлын байрны тоо | 2022 | 9 | 9 | Хадгалагдсан ажлын байрны тоо-11, шинэ ажлын байрны тоо-6 нийт 17 ажлын байр бий болсон байна. | |
| 3.3.1.5 | <u>Арга хэмжээ:</u> Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд | 2021-2024 | ЖДҮХСан-99,4 сая төгрөг | Малчин өрхийн тоо | 2022 | 5 | 6 | 2022 онд сүү, цагааны идээ боловсруулах 5 малчин өрх байсныг энэ онд эрчимжсэн аж ахуйн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэл эрхлэгч малчин өрхийн тоог нэмэгдүүлэх. | | | | | | | чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1 малчин өрхөөр нэмэгдүүлсэн. Баянжаргалан сумын малчин өрхийн Б.Цолмонбаатар, Д.Байгальмаа нар “Холбоо Бумбан” ХХК-г байгуулан ЖДҮХСангаас 99,400,000 төгрөгийн зээл авч эрчимжсэн мал, аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Цэвэр 100 хувийн хээлтүүлэгч азарга худалдан авсан. Ирэх жилээс үр, төлөө өгөн ашиг хүртэж эхэлнэ. 2 иргэнийг туслах малчнаар авч ажиллуулж байна. | |
| 3.3.1.6 | <u>Арга хэмжээ:</u> Ноос, ноолуур, арьс ширний анхан шатны үйлдвэр, цехийг байгуулах | 2021-2024 | ХХС-18,0 | Байгуулагдсан үйлдвэр цехийн тоо | 2022 | 5 | 7 | Адаацаг, Өндөршил сумдад арьс, нэхий элдэх анхан шатны 2 цех байгуулагдсан. 2022 онд 5 цех байсан бол 2023 онд шинээр 2 цех байгуулагдаж нийт 7 цех бий болсон. Энэ оны борлуулалтын орлого нь 10,700,000 төгрөг. | 100 |
| 3.3.1.7 | <u>Арга хэмжээ:</u> Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амыг жилийн турш шинэ ургацын нарийн ногоогоор тасралтгүй хангах | 2021-2024 | Хувийн хэвшил-14.5 ЖДҮ-179,5 | Өвлийн хүлэмжийн тоо | 2022 | 1 | 1 | Сайнцагаан сумын “Мөнгөлөг МД” ХХК өвлийн хүлэмжийн чиглэлээр 179.5 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдсан. Шинээр баригдаж байгаа хүлэмж 10*30 харьцаатай байна. Ажлын явц 80 хувьтай байна. | 100 |
| | | | | Хүлэмжийн тариалсан талбай (м2) | 2022 | 1780 | 1900 | Дэлгэрцогт сум 120м2, Өндөршил сум 100м2, Сайнцагаан сум 1860 м2 нийт Өвлийн хүлэмжид 2080 м.кв тариалалт хийсэн. Урд онтой харьцуулахад 300 м.кв нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хураан авах ургац хэмжээ (тн) | 2022 | 7.1 | 9.1 | Нийт 16 нэр, төрлийн хүнсний ногоо тариалж 19,02 тн ургац хураан авч аймгийн хүнсний ногооны 1,5 хувийг хангаж байна. | |
| 3.3.1.8 | <u>Арга хэмжээ:</u> Сайнцагаан сумд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж хүн амын хүнсний нарийн ногооны хэрэгцээг тасралтгүй хангах | 2021-2024 | Хувийн хэвшил-14,5 | Ашиглалтын хувь | 2022 | 75 | 85 | Өвлийн нарлаг хүлэмжийн 1200 мкв талбайн ашиглалтыг 100 хувь бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. | 100 |
| | | 2021-2024 | | хураан авсан ургацын хэмжээ(тн) | 2022 | 5.8 | 7.3 | 14.8 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 9 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 3.3.1.9 | <u>Арга хэмжээ:</u> Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах | 2021-2024 | ОНТ 542.6 сая | Бойжуулсан бизнес эрхлэгчийн тоо | 2022 | 60 | 72 | Түрээсийн төлбөр төлдөг иргэн, АА нэгжүүдийг урсгал зардлаа төлдөг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлсэн.<br>Бизнес хөгжлийн төвд 4 аж ахуй нэгж, 16 бизнес эрхлэгч нийт 20 хүнд Жижиг, дунд үйлдвэрийн газраас санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулж, үйл ажиллагааг тогтвортой явуулах, бизнесийг нь өргөжүүлэх зорилгоор шинээр нээгдсэн бизнес хөгжлийн төвд бойжуулж байна. | 80 |
| 3.3.2. | <u>Зорилт:</u> Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд шинээр нэвтрүүлж малын | 2021-2024 | ОНТ-3,5 сая.төг | Шинээр хамрагдсан малын тоо | 2022 | 500 | 700 | Энэ онд 500 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Битүү хөнгөлгөөний аргыг 250 хурга, 20 бяруунд туршиж, аймгийн хэмжээнд нийт 770 малд биотехнологийн ололтыг нэвтрүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хаврын амьдын жинг 3-5 хувиар нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Малчид - 1,0 сая | Малын амьдын жингийн өсөлт хувь | 2022 | 2 | 3 | Битүү хөнгөлгөө, зохиомол хээлтүүлэг зэрэг биотехнологийн дэвшилтэт аргыг ашигласнаар малын амьдын жинг 3-6 кг буюу жингийн өсөлт 5-10 хувиар нэмэгдүүлсэн. Хурганы гулуузны жин 18 кг байсныг дэвшилтэт технологи ашигласнаар 23 кг болж байна. | |
| 3.3.2.1 | <u>Арга хэмжээ:</u> Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх | 2021-2024 | ОНТ-2,5 сая .төг | Хээлтүүлсэн малын тоо | 2022 | 1300 | 1350 | Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч хээлтүүлэг хийсэн. Энэ онд 50 хонинд зохиомол хээлтүүлэг хийхээс 500 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийж, аймгийн хэмжээнд нийт 1850 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна | 100 |
| 3.3.2.2 | <u>Арга хэмжээ:</u> Олдохын хүрэн бор тэмээний тоог өсгөх замаар сумдад сайжруулагчаар ашиглах | 2021-2024 | Малчид хувь хөрөнгө-18,0 сая | Сайжрагдсан тэмээний тоо | 2022 | 650 | 720 | Хулдын Олдохын хүрэн бор омгийн бууран тайлгийг Өлзийт, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай сумдад 13 өсвөр буурыг захиалгын дагуу нийлүүлж, энэ онд 260 тэмээнд сайжруулагчаар ашиглаж байна. Нийт 910 тэмээнд сайжруулагчаар ашиглаж байна. Ингэснээр мах, ноосны чиглэлийн тэмээний тоо 910 болж, мах ноосны гарц сайжирч байна. | 100 |
| 3.3.2.3 | <u>Арга хэмжээ:</u> Малын удмын сангийн үндэсний төвийн гений санд омгоор баталгаажсан Өндөршил | 2022-2023 | | Тухайн жилд гений санд хадгалсан үрийн тун | 2022 | 500 | 300 | Малын удмын сангийн үндэсний төвийн гений санд Сайнцагаан омгийн 3 хуц, Монгол үүлдрийн 3 хуцнаас 1250 тун үр авч хадгалуулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | адуу, Сайнцагаан хонины үрийг хадгалах | | | | | | | Энэ онд малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран Өндөршил омгийн 2 азарганаас 300 тун үрийг авч генийн санд хадгалуулсан. | |
| 3.3.2.4 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн хэмжээнд үхэр сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021-2024 | Сумын ОНХС-4,5 | Ашиг шим нь нэмэгдсэн үхэр сүргийн тоо | 2022 | 140 | 210 | Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 өсвөр хээлтүүлэгчээр 150 үхэрт сайжруулагчаар ашиглаж, энэ онд ашиг шим нэмэгдсэн үхрийн тоо 150 хүрсэн. Мөн Адаацаг суманд энэ онд махны чиглэлийн казакын цагаан толгойт үүлдрийн 3-н бухан бяруug сайжруулагчаар ашиглаж, энэ онд ашиг шим нэмэгдсэн үхрийн тоо 45 болж, нийт ашиг шим нь нэмэгдсэн үхэр сүргийн тоо 195 болсон.<br>Сэлэнгэ үүлдрийн үхрийн гүн хөлдөөсөн үрээр Луус суманд зохиомол хээлтүүлгийг 15 үхэрт хийсэн ба 10 төл хүлээж авсан. Нийт ашиг шим нь нэмэгдсэн төл 205 болоод байна. | 92,8 |
| 3.3.2.5 | <u>Арга хэмжээ</u>: Баянжаргалан сумын үхэр сүргийг "Дорнод монголын мухар улаан" үүлдрээр сайжруулах | 2021-2024 | хувь хөрөнгө - 50,0 | Тухайн жилд сайжрагдсан үхрийн тоо | 2021 | 10 | 10 | Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 өсвөр бухыг 150 үнээнд сайжруулагчаар ашигласнаар анхны төлийг хүлээн аваад байна. Төл бойжилт 100 хувь буюу 150 тугал бойжоод байна. Нийт "Дорнод монголын мухар улаан" үүлдрээр сайжрагдсан үхрийн тоо 150 боллоо. | 100 |
| 3.3.2.6 | <u>Арга хэмжээ:</u> Жилд 20-оос доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах | 2021-2024 | малчид ОН-7.0 | Бойжуулсан бухын тоо | 2022 | 1004 | 1024 | Аймгийн хэмжээнд орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлаж шинээр 35 өсвөр бухыг тавьснаар 1040 стандартын шаардлага | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хангасан бухыг бойжуулж үхэр сүргийг сайжруулж байна. | |
| 3.3.2.7 | <u>Арга хэмжээ:</u> Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах | 2021-2024 | Малчид, ОН-10,0 | Ээмэгжүүлж бүртгэлжүүлсэн малын тоо.мян | 2022 | 96 | 100 | 2023 онд 4000 малыг шинээр ээмэгжүүлж, бүртгэлжүүлэхээс стандартын шаардлага хангасан хуц 6202, ухна 4299 бүгд 10501 хээлтүүлэгчийг ээмэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд ээмэгний дахин давтагдашгүй дугаараар үржлийн малыг бүртгэж байна. Нийт ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн малын тоо 106500 болж хүрэх түвшиндээ хүрсэн байна. | 100 |
| 3.3.3. | <u>Зорилт:</u> Нийт 7.4 сая га бэлчээрийн талбайн 70 хувьд бэлчээрийн даац 3 дахин илүү хэтрэлттэй байгаагийн 26 га талбайг 2024 гэхэд нөхөн сэргээнэ. | 2021-2024 | УТ, ОНТ, Малчид, Төсөл хөтөлбөр-2592,7 | Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ (га) | 2022 | 6 | 7 | Энэ онд өвөлжөө, хаваржааны дэргэд 567 га бэлчээр хашиж, 15,9 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 40000 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэн нийт 40,5 мянган га бэлчээрийн талбайг нөхөн сэргээгээд байна. | 100 |
| 3.3.3.1 | <u>Арга хэмжээ:</u> Олон дахин хэтэрсэн болон талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээх | 2021-2024 | ОНТ, Төсөл хөтөлбөр, Малчид 89,5сая/төг | Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ (га) | 2022 | 11 | 18 | Дэлхийн зөн олон улсын байгууллага, малчдын хувийн хөрөнгө 101,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянжаргалан, Гурвансайхан, Луус, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр сумдын малчид, Эрдэнэдалай сумын малчдын бүлэг 15,9 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 15,8 тн ургац хураан авсан. 2022 онд 12 га талбайд тэжээлийн ургамал | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тариалсан бол нийт нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 27,9 га боллоо. | |
| 3.3.3.3 | <u>Арга хэмжээ:</u> Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 2021-2024 | Малчид 1134,0 | Хамгаалсан талбайн хэмжээ (мян/га) | 2022 | 278 | 285 | Малчид 1,134,0 сая төгрөгийн хувь хөрөнгөөр Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 36 малчин өрх өвөлжөө, хаваржаагаа түшиглэн энэ онд шинээр 567 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалсан.<br><br>Өмнөх жилүүдэд нийт хашсан талбайн хэмжээ 310,3 га байсан ба 877,3 га талбайг хашиж хамгаалсан. Байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан малчид өвөлжөө хаваржааны ойролцоо нөөц бэлчээр хашиж байдал нэмэгдэж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.4 | Арга хэмжээ: Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах | 2021-2024 | УТ, ОНТ 167,0 сая төг | Тэмцсэн талбайн хэмжээ (мян/га) | 2022 | 160 | 190 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоол “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/218, А/587 дугаар захирамжийн дагуу Улсын төсвийн 167,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан ,Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 10,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, 30,0 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар, энэ онд нийт 40,0 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулж, нийт 199,5 мян/га талбайд тэмцсэн. | 100 |
| 3.3.3.5 | Арга хэмжээ: Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах | 2021-2024 | УТ, ОНТ Малчид 1,190,4 сая/төг | Тухайн жилд шинээр гаргах худгийн тоо | 2022 | 3 | 3 | Улсын төсөв, орон нутгийн төсвийн 1,190,4 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Луус ,Өлзийт сумд инженерийн хийцтэй 18 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд 30 цооног шинээр энэ онд нийт 48 худгийг шинээр гаргасан. | 100 |
| 1зорилго | | | | | | | | | 100 |
| 3 зорилтын хэрэгжилт | | | | | | | | | 100 |
| 20 арга хэмжээний хэрэгжилт | | | | | | | | | 89,5 |

| | |
|---|---|
| Хэрэгжилтийн дундаж хувь | 94,7 |

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХЖАРГАЛ
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(гарын үсгийн тайлал)*

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА Ж.ШИНЭ-УЯНГА
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(гарын үсгийн тайлал*